

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ᠠᠷᠬᠠᠩᠭ᠋ᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠶᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ОРЛОГЫГ 834.3 САЯ
ТӨГРӨГӨӨР ДУТУУ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА

АУДИТЫН НЭР: МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ,
СУМЫН 2022 ОНЫ ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ

АУДИТЫН КОД:
АРА-2023/31-01-ШТА-НА



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatard@audit.gov.mn
Багийн ахлагч, ахлах аудитор Н.Алтантуяа
Утас: 70333019 Цахим хаяг: altantuyan@audit.gov.mn
Аудитор В.Цогжаргал
Утас: 7033-3019 Цахим хаяг: tsogjargalv@audit.gov.mn

ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2023 ОН

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



<p>Тайлан бэлтгэсэн: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар</p>	<p>Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</p>
<p>Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар</p> <p>Ахлах аудитор Н.Алтантуяа</p> <p>Аудитор В.Цогжаргал</p> <p>А.Пүрэвцэцэг</p> <p>2023 оны 07 дугаар сар</p> <p>Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033-3141 дугаарын факсаар харилцана уу</p> <p>Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот</p>	<p>Бүлэг 1. МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.</p> <p>А.1 Малын тоо толгойн албан татварыг хуульд заасны дагуу бүрэн ногдуулаагүй, орлого бүрдүүлэлт хангалтгүй байна.</p> <p>А.2 Сумын ИТХ, ЗДТГ нь малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлсэн 406.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 20 төсөл арга хэмжээг иргэдийн саналгүйгээр төлөвлөж гүйцэтгэсэн байна.</p> <p>БҮЛЭГ 2. МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРЭЭР ХЭРЭГЖСЭН ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ХУУЛЬД ЗААСАН ЧИГ ҮҮРЭГТЭЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.</p> <p>Б.1 Хуульд заасан чиг үүрэгт хамааралгүй 59.0 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.</p> <p>Б.2 Нийт төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 29.0 хувь буюу 1,202.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээ нь татварын орлого бүрдүүлэлтээс хамаарч хэрэгжээгүй байна.</p> <p>Б.3 Малын тоо толгойн албан татварын санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.</p> <p>БҮЛЭГ 3. МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.</p> <p>В.1 Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах үйл ажиллагаанд тавих хяналт үр дүн багатай байна.</p> <p>В.2 Малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.</p> <p>В.3 Малын тоо толгойн албан татвараас санхүүжүүлсэн ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцын мэдээллийг зарим сум удирдлага мэдээллийн системд бүрэн оруулаагүй байна.</p> <p>Зөвлөмж Тайлан баталгаажуулсан тушаал Холбогдох байгууллагын санал Хавсралт:Судалгаанууд</p> <p>Хүснэгт № 1-7 График № 1-3 Зураг № 1-8</p>



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
УИХ	Улсын их хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл арга хэмжээ

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар
1	Малын тоо толгойн албан татварын ногдуулалт
2	Сумын ИТХ-аас тогтоосон албан татварын хэмжээ
3	Төрийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл
4	Татварын нэгдсэн системд 2022 онд үүсгэсэн малын тоо толгойн албан татварын ногдол буюу нэхэмжилсэн татвар, барагдуулалт, өрийн үлдэгдэл
5	Иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээ
6	Чиг үүрэгт хамааралгүй төсөл, арга хэмжээ
7	Бүртгэл тайланд тусгаагүй хөрөнгө

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар
1	Архангай аймгийн 2022-2023 оны бэлчээрийн даац
2	Төсөл арга хэмжээний тендер сонгон шалгаруулалт
3	Төсөл арга хэмжээний эзлэх хувь хэмжээ
4	Төсөл арга хэмжээний гүйцэтгэл



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Аудитын жилийн төлөвлөгөө”-г үндэслэн Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилт, сумын 2022 оны татварын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг аймгийн ИТХ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын орлогыг хуульд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн эсэх;
- Малын тоо толгойн албан татварын эх үүсвэрээр санхүүжсэн төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх;
- Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хууль журмын дагуу хяналт тавьж ажилласан эсэх;

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Аудитад аймгийн 19 сумын 2022 оны Малын тоо толгойн албан татварын ногдуулалт, төлөвлөлт, орлого бүрдүүлэлт, хуваарилалт, ОНХС-аар хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлангийн баримт материалууд, сумын ИТХ, ЗДТГ, аймгийн ЗДТГ-ын СТСХ, Татварын хэлтэс, сумын болон багийн Засаг дарга, багийн ИНХ-ын баримт шаардлагатай баримт материалуудыг хамруулав.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг АДБОУС-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан баримт бичгийг хянах, нийцлийг шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

АУДИТАД АШИГЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;



- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Бусад холбогдох хууль, эрх зүйн актууд

АУДИТ ХИЙХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН ХУГАЦАА:

Аудитыг Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ахлах аудитор Н.Алтантуяа, аудитор В.Цогжаргал, А.Пүрэвцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2023 оны 05 сарын 01-ний өдрөөс эхлэн 2023 оны 07 сарын 03-ны хооронд гүйцэтгэв.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Архангай аймгийн хэмжээнд 2022 онд 5.9 сая толгой мал тоологдсон нь 10 жилийн өмнөх 2012 онд тоологдож байсан 3.4 сая толгой малтай харьцуулахад 38.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Мал сүргийн зөв бүтцийг бий болгох, бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх, цөлжилтийг бууруулах зорилгоор 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн УИХ-аас Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг баталж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр заасан.

Малын тоо толгойн албан татварын орлогыг 2022 онд 19 сумын хэмжээнд нийт 2,348.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,757.9 сая төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 591.0 сая төгрөгөөр буюу 25.2 хувиар тасалжээ. Сумдын дүнгээр авч үзвэл 4 сум орлогын төлөвлөгөөг 16-366 хувиар давуулж, 15 сум төлөвлөгөөг 4.1-79.7 хувиар тасалсан байна.

Сумдын ИТХ-аар баталсан Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг авч үзэхэд дунджаар нэг толгой тэмээнд 347 төгрөг, адуунд 842 төгрөг, үхэрт 737, ямаанд 553 төгрөг, хонинд 363 төгрөгийн албан татвар ногдуулахаар тогтоосон байна.

Малын тоо толгойн албан татварын орлогоос ОНХС-д төвлөрүүлсэн хөрөнгийг дараах хууль тогтоомжийн дагуу зарцуулахаар тусгажээ. Үүнд:

1. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д “Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.
2. Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.5¹-д заасан арга хэмжээнүүдэд зарцуулна.

¹ 4.5.Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ



БҮЛЭГ 1. МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

A.1 Малын тоо толгойн албан татварыг хуульд заасны дагуу бүрэн ногдуулаагүй, орлого бүрдүүлэлт хангалтгүй байна.

A1.1 Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1², 5.2³, 5.3⁴-т заасны дагуу татварын нэгдсэн системд ногдлыг бүрэн үүсгээгүй байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу албан татварын ногдуулалтыг Статистикийн хэлтсээс гаргасан өмнөх оны малын тоо, сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан албан татварын хэмжээг үндэслэн дахин тооцоолж, татварын нэгдсэн системд үүсгэсэн 2022 оны ногдуулалттай харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №1 Малын тоо толгойн албан татварын ногдуулалт

мянган төгрөгөөр

№	Сумын нэр	Аудитаар тооцсон ногдуулалт	Татварын нэгдсэн системд үүссэн ногдол /нэхэмжлэхийн дүн /	Зөрүү
A	1	2	3	4=2-3
1	Ихтамир	200,039.4	198,228.2	1,811.2
2	Чулуут	108,069.0	105,965.0	2,104.0
3	Хангай	66,245.8	55,479.3	10,766.5
4	Тариат	125,551.1	121,284.4	4,266.7
5	Өндөр-Улаан	200,946.7	187,112.1	13,834.6
6	Эрдэнэмандал	282,359.7	261,797.0	20,562.7
7	Жаргалант	171,863.9	163,278.2	8,585.7
8	Цэцэрлэг	97,025.9	93,463.3	3,562.6
9	Хайрхан	236,691.4	233,624.6	3,066.8
10	Батцэнгэл	163,187.4	159,892.0	3,295.4
11	Өлзийт	131,365.8	127,304.2	4,061.6
12	Өгийнуур	105,659.4	103,834.0	1,825.4
13	Хашаат	115,698.2	112,099.3	3,598.9
14	Хотонт	254,383.4	130,293.2	124,090.2
15	Цэнхэр	119,982.3	114,340.6	5,641.7
16	Төвшрүүлэх	79,045.8	34,291.1	44,754.7
17	Булган	66,987.3	50,386.4	16,600.9
18	Цахир	66,550.9	51,895.3	14,655.6
19	Эрдэнэбулган	108,580.0	103,278.8	5,301.2
		2,700,233.4	2,407,847.0	292,386.4

Тайлбар: Эрдэнэмандал суманд 2022 онд байгалийн гамшигт үзэгдэл үер болж, 3537 толгой хонь, 1596 толгой ямааг Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т заасны дагуу албан татвар ногдуулах малын тооноос хасаж, Өгийнуур сум 72027 толгой, Хашаат 79704 толгой, Булган сум 38058 толгой малыг сумын ИТХ-ын тогтоолын дагуу 0 хэмжээгээр татвар ногдуулсныг аудитаар тооцсон тооцоололд оруулсан болно.

² 5.1. Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна.

³ 5.2. Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно.

⁴ 5.3. Тухайн татварын жилд албан татвар ногдуулах энэ хуулийн 5.2-т зааснаар тодорхойлсон малын тоо толгой нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан гамшгийн улмаас хорогдсон бол нотлох баримтыг үндэслэн түүнийг албан татвар ногдуулах нийт малын тооноос хасна.



Хүснэгтээс харахад 2022 онд аудитаар 2,700.2 сая төгрөгийн татвар төлөх тооцоо гарч байхад татварын ногдлоор 2,407.8 сая төгрөгийн нэхэмжлэх үүсгэсэн нь аудитаар тооцсоноос 292.4 сая төгрөгөөр дутуу байна.

Аймгийн Татварын хэлтсээс дутуу ногдол үүсгэсэн талаар ирүүлсэн тайлбар:

Үндэсний статистикийн хорооноос мал тооллогын нэгдсэн дүнг Татварын ерөнхий газарт ирүүлдэг бөгөөд мэдээлэлд үндэслэн Татварын удирдлага мэдээллийн нэгдсэн системд сумын ИТХ-ын тогтоосон хувь хэмжээгээр мэдээллийн сан үүсгэдэг. Харин урьд оны татварын өрийг төлөөгүй тохиолдолд тайлант онд шинээр нэхэмжлэх буюу ногдуулалт үүсгэх боломжгүй байдаг.

Тайлбараас үзэхэд албан татварыг Статистикийн хэлтсээс гаргасан малын тоонд үндэслэн ногдуулж байгаа боловч өмнөх оны татварын өр төлөгдөөгүй бол сумын татварын улсын байцаагч нар тайлант оны нэхэмжлэхийг Татварын нэгдсэн системд шинээр үүсгэх боломжгүй болж, татварын ногдол дутуу үүсч байна. Тухайлбал: Хотонт сум аудитаар тооцсон дүнгээс 124.1 сая, Төвшрүүлэх сум 44.7 сая, Эрдэнэмандал сум 20.6 сая, Цахир сум 14.6 сая төгрөгийн г.м бүх суманд нийт 292.4 сая төгрөгийн нэхэмжлэх үүсгээгүй байна.

Аудитын явцад 2022 оны татварын ногдуулалттай холбоотой мэдээлэл нь Татварын нэгдсэн системээс бүрэн хэмжээнд татагдахгүй, мэдээлэл зөрүүтэй байдал ажиглагдсан.

A1.2 Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2⁵, 6.3⁶-т заасны дагуу албан татварын хувь хэмжээг тогтоосон байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Нэг тоо толгой малд тухайн татварын жилд ногдуулах татварын хэмжээ нь 0-2000 төгрөг байхаар заасныг сумдаар авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт № 2 Сумын ИТХ-аас тогтоосон албан татварын хэмжээ

төгрөгөөр

№	Сумын нэр	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
A	1	2	3	4	5	6
1	Ихтамир	800	800	800	400	600
2	Чулуут	900	800	0	300	500
3	Хангай	1000	800	0	300	500
4	Тариат	800	600	0	300	600
5	Өндөр-Улаан	900	800	0	400	600
6	Эрдэнэмандал	1000	1000	0	500	600
7	Жаргалант	1000	1000	1000	500	700
8	Цэцэрлэг	500	500	500	200	300
9	Хайрхан	1000	600	1000	500	800
10	Батцэнгэл	600	600	0	300	500
11	Өлзийт	800	800	800	300	300
12	Өгийнуур	1000	700	700	300	500
13	Хашаат	700	700	500	400	500
14	Хотонт	1000	1000	0	600	1000
15	Цэнхэр	800	500	500	200	300
16	Төвшрүүлэх	600	400	500	300	600
17	Булган	1000	1000	0	300	500
18	Цахир	1000	800	0	400	700
19	Эрдэнэбулган	600	600	300	400	400
	Аймгийн дундаж	842	737	347	363	553

⁵ 6.2. Албан татварын хэмжээг энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно.

⁶ 6.3. Малчны амьжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоож болно.



Хүснэгтээс харахад ногдуулах татварын хэмжээг аймгийн дунджаас багаар тогтоосон сум нь:

- Адуу- Цэцэрлэг, Төвшрүүлэх, Эрдэнэбулган,
- Үхэр- Төвшрүүлэх, Цэнхэр, Цэцэрлэг, Хайрхан, Батцэнгэл, Эрдэнэбулган,
- Хонь -Цэцэрлэг, Цэнхэр сум,
- Ямаа- Цэнхэр, Өлзийт, Цэцэрлэг, Эрдэнэбулган байна.

Харин аймгийн дунджаас өндөр тогтоосон сум нь:

- Адуу – Хангай, Эрдэнэмандал, Жаргалант, Хайрхан, Өгийнуур, Хотонт, Булган, Цахир сум 1000 төгрөгөөр,
- Үхэр – Эрдэнэмандал, Жаргалант, Хотонт, Булган сум 1000 төгрөгөөр,
- Тэмээ - Жаргалант, Хайрхан сум 1000 төгрөгөөр,
- Хонь - Эрдэнэмандал, Жаргалант – 500 төгрөгөөр, Хотонт 600 төгрөгөөр,
- Ямаа – Хотонт 1000 төгрөг, Хайрхан 800 төгрөг, Жаргалант, Цахир сумд 700 төгрөгөөр тогтоосон байна.

Цэцэрлэг, Эрдэнэбулган, Цэнхэр сумд малын бүх төрөл дээр албан татварын хэмжээг аймгийн дунджаас багаар тогтоосон байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу албан татварын хэмжээг аймгийн бүх сумын ИТХ-аас малын төрөл тус бүрээр тогтоосон байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Малчны амьжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоож болно” гэж заасны дагуу 2022 онд дараах сумд албан татварын хэмжээг “0” байхаар тогтоосон байна.

- Өгийнуур сум малчны өмчилж байгаа тэмээ, адуунд 5, үхэр 10, хонь 60, ямаанд 20 толгой мал,
- Хашаат сум тэмээ 6, адуу, үхэрт 12, хонь 65, ямаа 40 толгой мал,
- Булган сум адуу 20, үхэр 30, хонь, ямаа 50 толгой малд тус бүрийг албан татвараас чөлөөлсөн байна.

А1.3. Сумдын тогтоосон малын тоо толгойн албан татварын хэмжээ нь бэлчээрийн даацын хэтрэлт, бэлчээрийн доройтлоос сэргийлэх хөшүүрэг болж чадахгүй байна.

Архангай аймаг нь 55,300 км² газар нутагтай бөгөөд нийт нутгийн 15.7 хувийг ой мод, 75 хувийг бэлчээр, 1.5 хувийг тариалангийн талбай эзэлдэг. Аймгийн ус цаг орчны шинжилгээний төвөөс ирүүлсэн мэдээгээр манай аймгийн нийт нутгийн 6.5 хувь нь бэлчээрийн нөөцтэй, 15.4 хувь нь бэлчээр хүрэлцээтэй, 66.5 хувь нь бэлчээрийн даац 1-3 дахин хэтэрсэн, 10.2 хувь нь бэлчээрийн 3-5 дахин хэтэрсэн, 1.5 хувь нь бэлчээр олон дахин хэтэрсэн байна.



Дүрслэл №1



Сүүлийн 3 жилд буюу 2020 онд 5.4 сая, 2021 онд 5.6 сая, 2022 онд 5.9 сая мал тоологдсон ба 2022 оны малын тоог 2020 онтой харьцуулахад 8.2 хувиар, 2021 онтой харьцуулахад 5.5 хувиар өссөн байна.

Бэлчээрийн доройтлоос сэргийлэх зорилгоор бэлчээрийг их хэмжээгээр талхалдаг адуунд Чулуут, Өндөр-Улаан сумд 900 төгрөгөөр, бусад 8 сум 1000 төгрөгөөр, ямаанд Жаргалант, Цахир сумд 700 төгрөгөөр, Хотонт сум 1000 төгрөгөөр татварын хэмжээг тогтоосон байна.

Гэвч сумдын тогтоосон малын тоо толгойн албан татварын хэмжээ нь бэлчээрийн даацын хэтрэлт, бэлчээрийн доройтлоос сэргийлэх хөшүүрэг болохгүй байна.

А1.4. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1⁷-д заасны дагуу албан татварыг сумын төсөвт бүрэн төвлөрүүлээгүй бөгөөд 2023 оны эхний хагас жилийн байдлаар 834.3 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Аймгийн СТСХ-ийн 2022 оны татварын төлөвлөгөөгөөр Малын тоо толгойн албан татварыг нийт 2,348.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,757.9 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 74.8 хувиар биелүүлсэн мэдээтэй байна. Гэтэл аймгийн Татварын хэлтсийн мэдээгээр 1,766.0 сая төгрөгийн гүйцэтгэлийг тайлагнасан нь замд яваа гүйлгээтэй холбоотой байна. Төрийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг сумдаар авч үзвэл:

⁷ 7.1. Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө.



Хүснэгт №3 Төрийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл

мянган төгрөгөөр

№	Сумын нэрс	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Ихтамир	180,500.0	140,176.4	(40,323.6)	77.7
2	Чулуут	112,777.7	99,634.3	(13,143.4)	88.3
3	Хангай	74,337.3	65,084.2	(9,253.1)	87.6
4	Тариат	134,999.9	94,503.8	(40,496.1)	70.0
5	Өндөр-Улаан	211,969.3	131,096.8	(80,872.5)	61.8
6	Эрдэнэмандал	250,438.6	240,159.1	(10,279.5)	95.9
7	Жаргалант	32,325.6	150,736.7	118,411.1	466.3
8	Цэцэрлэг	82,690.0	96,634.1	13,944.1	116.9
9	Хайрхан	226,159.7	85,850.0	(140,309.7)	38.0
10	Батцэнгэл	162,076.9	85,065.4	(77,011.5)	52.5
11	Өлзийт	113,608.5	77,547.5	(36,061.0)	68.3
12	Өгийнуур	101,497.1	81,990.0	(19,507.1)	80.8
13	Хашаат	80,000.0	70,213.0	(9,787.0)	87.8
14	Хотонт	240,958.6	48,895.5	(192,063.1)	20.3
15	Цэнхэр	114,901.6	94,319.7	(20,581.9)	82.1
16	Төвшрүүлэх	25,500.0	39,686.7	14,186.7	155.6
17	Булган	61,500.0	45,500.7	(15,999.3)	74.0
18	Эрдэнэбулган	103,180.6	58,590.8	(44,589.8)	56.8
19	Цахир	39,500.0	52,263.3	12,763.3	132.3
	Нийт дүн	2,348,921.4	1,757,948.0	(590,973.4)	74.8

Эх сурвалж: Аймгийн СТСХ-ийн мэдээ

Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг Жаргалант сум нэмэгдүүлэн тогтоосноос татварын орлого өндөр дүнгээр давж биелсэн бол орлогын төлөвлөгөөг Хотонт, Хайрхан сум хамгийн өндөр дүнгээр тасалсан байна.

Аймгийн СТСХ нь 2022 оны орлогын төлөвлөгөөг 2021 оны 8 дугаар сард төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлэхдээ 2020 оны жилийн эцэст тоологдсон малын тоо толгойд үндэслэсэн учраас аймгийн Татварын хэлтсийн 2022 онд үүсгэсэн Татварын нэгдсэн систем дэх ногдуулалттай уялдаагүй байна.

Татварын нэгдсэн системд 2022 онд үүсгэсэн малын тоо толгойн албан татварын ногдол буюу нэхэмжилсэн татвар, барагдуулалтын зөрүүгээр 2022 оны жилийн эцэст татварын өрийн үлдэгдэл 1,056.7 сая төгрөг байсан бол Татварын нэгдсэн системд оруулсан 2023 оны эхний хагас жилийн байдлаарх гүйцэтгэлийг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар авч үзэхэд аймгийн 19 сумын хэмжээнд 834.3 сая төгрөг татварын өрийн үлдэгдэлтэй байна. Хүснэгтээр харуулбал:



Хүснэгт № 4 Татварын нэгдсэн системд 2022 онд үүсгэсэн малын тоо толгойн албан татварын ногдол буюу нэхэмжилсэн татвар, барагдуулалт, өрийн үлдэгдэл мянган төгрөгөөр

№	Сумын нэр	Нийт ногдол үүссэн татвар төлөгчийн тоо	2022 оны нийт ногдуулалт /нэхэмжлэхийн дүнгээр/	2022 оны гүйцэтгэл	2023 оны хагас жилийн гүйцэтгэл	Татварын өрийн үлдэгдэл
1	Ихтамир	1,246	198,228.2	105,241.7	19,641.9	73,344.6
2	Чулуут	988	105,965.0	80,049.2	8,940.0	16,975.8
3	Хангай	719	55,479.3	50,861.5	956.9	3,660.9
4	Тариат	1,234	121,284.4	86,202.3	3,239.7	31,842.4
5	Өндөр-улаан	1,358	187,112.1	108,117.1	12,803.4	66,191.6
6	Эрдэнэмандал	1,338	261,797.0	168,793.2	20,188.4	72,815.4
7	Жаргалант	1,019	163,278.2	135,950.1	2,120.5	25,207.6
8	Цэцэрлэг	946	93,463.3	90,353.7	3,109.6	0.0
9	Хайрхан	1,153	233,624.6	64,012.8	12,254.4	157,357.4
10	Батцэнгэл	1,075	159,892.0	76,644.4	8,850.0	74,397.6
11	Өлзийт	870	127,304.2	68,511.9	24,621.7	34,170.6
12	Өгийнуур	783	103,834.0	66,123.7	26,024.4	11,685.9
13	Хашаат	736	112,099.3	49,011.1	15,603.1	47,485.1
14	Хотонт	1,252	130,293.2	10,583.5	27,721.7	91,988.0
15	Цэнхэр	1,433	114,340.6	71,077.8	17,059.6	26,203.2
16	Төвшрүүлэх	276	34,291.1	10,527.6	2,936.7	20,826.8
17	Булган	497	50,386.4	31,107.5	8,783.2	10,495.7
18	Цахир	527	51,895.3	38,932.8	684.0	12,278.5
19	Эрдэнэбулган	1,265	103,278.8	39,117.3	6,722.8	57,438.7
НИЙТ ДҮН		18,715	2,407,847.0	1,351,219.2	222,262.0	834,365.8

Эх сурвалж: Татварын хэлтэс- Татварын нэгдсэн сангаас

Хүснэгтээс харахад татварын өрийн үлдэгдлийн хэмжээ Хайрхан, Хотонт, Батцэнгэл, Ихтамир, Эрдэнэмандал сумдад харьцангуй өндөр байна.

Нийт 834.3 сая төгрөгийн малчин болон мал бүхий иргэний татварын өрийн үлдэгдлийг барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах хугацаатай албан шаардлагыг аймгийн Татварын хэлтэст хүргүүллээ.

А1.5. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3⁸, 7.4⁹-т заасны дагуу татварын тайланг Татварын цахим тайлангийн системээр тайлагнаж байгаа ба тайлангийн ирц 96.0 хувьтай байна.

⁸ 7.3.Албан татвар төлөгч албан татварын тайланг батлагдсан маягтын дагуу бэлтгэж, тухайн татварын жилийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор харьяа татварын албанд хүргүүлнэ.

⁹ 7.4.Энэ хуулийн дагуу албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам, тайлангийн маягтыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.



Аймгийн Татварын хэлтсийн 2022 оны малын тоо толгойн албан татварын ирцийн тайлангаас үзэхэд аймгийн хэмжээнд 21,261 ирүүлбэл зохих тайлангаас 20,473 тайланг ирүүлж, 96 хувийн гүйцэтгэлтэй, 788 тайланг ирүүлээгүй байна.

Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасны дагуу татварын тайланг малчид өөрсдөө маягтын дагуу бэлтгэж, жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор татварын албанд ирүүлэхээр заасан хэдий ч цахилгаан, интернэт, утасны сүлжээ зэргээс хамааран татварын тайланг илгээх бүрэн боломжгүй байдаг бөгөөд сумын татварын улсын байцаагч нар тус ажлыг гүйцэтгэж байгаатай холбоотой юм.

А.2 Сумын ИТХ, ЗДТГ нь малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлсэн 406.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 20 төсөл арга хэмжээг иргэдийн саналгүйгээр төлөвлөж гүйцэтгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, 60.2.8-д малын тоо толгойн албан татвар нь сумын ОНХС-ийн эх үүсвэр болно гэж заасны дагуу малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт нь Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу хийгдэж байна.

А.2.1 Дээрх журмын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр дараагийн жилд хийгдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээнд иргэдийн саналыг авч, багийн ИНХ-аас эрэмбэлсэн жагсаалтыг ЗДТГ-ын ажлын хэсэг тухайн орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, иргэдийн санал авсан төсөл арга хэмжээг нэгтгэн эрэмбэлэн хэлэлцүүлж, сумын ИТХ-аар баталж байна.

А.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 88.8 хувьд иргэдийн саналыг авсан байна.

2022 онд аймгийн 19 сумын хэмжээнд өмнөх оноос шилжсэн 1 төсөл арга хэмжээнд 15.0 сая төгрөг, шинэ оны 177 төсөл арга хэмжээнд 3,611.3 сая төгрөг нийт 178 төсөл арга хэмжээнд 3,626.3 сая төгрөг төлөвлөснөөс 88.8 хувь буюу 3,219.5 сая төгрөгийн 158 төсөл арга хэмжээг иргэдийн саналд үндэслэн эрэмбэлсэн бол **6 сум 406.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 20 төсөл арга хэмжээнд иргэдийн саналыг эрэмбэлээгүй төлөвлөж гүйцэтгэсэн байна.** Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт№5 Иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээ мянган төгрөгөөр

№	Сумын нэр	ТАХ ний тоо	Мөнгөн дүн
1	Өндөр-Улаан	1	20,000.0
2	Чулуут	2	23,000.0
3	Тариат	4	65,000.0
4	Ихтамир	4	138,362.8
5	Эрдэнэбулган	5	82,215.5
6	Хайрхан	4	78,212.3
	Дүн	20	406,790.6

Аудитаас зөрчлийг таслан зогсоож, Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлагыг дээрх сумдын Засаг дарга нарт хүргүүлээд байна.



БҮЛЭГ 2. МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРЭЭР ХЭРЭГЖСЭН ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ХУУЛЬД ЗААСАН ЧИГ ҮҮРЭГТЭЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.


Б1. Хуульд заасан чиг үүрэгт хамааралгүй 59.0 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Б1.1 Малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн хэмжээнд 2022 онд шинээр нийт **3,611.3** сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 177 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар сумдын ИТХ-аар баталснаас гүйцэтгэл **65.8** хувьтай байгаа бөгөөд мал тоо толгойн албан татварын орлого бүрдүүлэлт дутуу, тендер зарласан боловч оролцогчгүй байсан зэргээс шалтгаалж, **1,234.7** сая төгрөгийн 52 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна.

Нийт **2,391.6** сая төгрөгийн 126 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны зохион байгуулалтыг авч үзвэл:

Дүрслэл № 2 Төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалт



- 590.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл арга хэмжээг **нээлттэй тендер** шалгаруулалтаар,
- 499.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 16 төсөл арга хэмжээг **харьцуулалтын** аргаар,
- 1,266.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 100 төсөл арга хэмжээг **шууд гэрээ**,
- 35.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл арга хэмжээнд **Олон нийтийн оролцоотой худалдан авалт** байна.

2022 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан нийт төсөл арга хэмжээний 79.3 хувь нь шууд гэрээ байгуулжээ. Энэ нь төсвийг хувааж урсгал шинжтэй зардалд зарцуулж байгаатай холбоотой байна.

Б1.2 Олгосон санхүүжилтийн 3.0 хувийг зориулалт бус болон хуульд заасан чиг үүрэгт хамааралгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

Аймгийн хэмжээнд 2022 онд малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр өмнөх оноос шилжин ирсэн 1 төсөл арга хэмжээнд 15.0 сая, тайлант оны 177 төсөл арга хэмжээнд 3,611.3 сая нийт 178 төсөл арга хэмжээнд 3,626.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр **71.3** хувь буюу **127** төсөл арга хэмжээнд **1,971.7** сая төгрөг зарцуулсан байна.

Хэрэгжүүлсэн 127 төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д, ОНХС-ийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүргээр ангилан харуулбал дараах байдалтай байна.

Журмын 4.5.1 “Бэлчээрийн менежментийг сайжруулах” чиг үүргийн дагуу 1 төсөл арга хэмжээнд 14.0 сая төгрөг,

Журмын 4.5.2 “Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;/хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхийг хашиж



хамгаалах/ чиг үүргийн дагуу 26 төсөл арга хэмжээнд 645.4 сая төгрөг,

Журмын 4.5.3 “Малын эрүүл мэндийг хамгаалах” чиг үүргийн дагуу 19 төсөл арга хэмжээнд 291.5 сая төгрөг,

Журмын 4.5.4 “Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх” чиг үүргийн дагуу 9 төсөл арга хэмжээнд 97.3 сая төгрөг,

Журмын 4.5.8 “Малын тэжээлийн ургамал тариалах” чиг үүргийн дагуу 5 төсөл арга хэмжээнд 62.6 сая төгрөг

Журмын 4.5.9 “Тэжээлийн нөөц бүрдүүлэх” чиг үүргийн дагуу 8 төсөл арга хэмжээнд 241.2 сая төгрөг

Журмын 4.5.10 “Байгаль орчныг хамгаалах” чиг үүргийн дагуу 12 төсөл арга хэмжээнд 133.1 сая төгрөг

Журмын 4.5.5 “Малын чанарыг сайжруулах” чиг үүргийн дагуу 8 төсөл арга хэмжээнд 140.2 сая төгрөг,

Журмын 4.5.6 “Гэмт халдлага, гамшгаас хамгаалах” чиг үүргийн дагуу 8 төсөл арга хэмжээнд 54.2 сая төгрөг,

Журмын 4.5.7 “Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх” чиг үүргийн дагуу 1 төсөл арга хэмжээнд 0.4 сая төгрөг,


Журмын 4.5.11 “Хортон мэрэгчидтэй тэмцэх/байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/” чиг үүргийн дагуу 7 төсөл арга хэмжээнд 88.2 сая төгрөг

Журмын 4.5.12 “Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа” чиг үүргийн дагуу 16 төсөл арга хэмжээнд 144.6 сая төгрөг

Хууль, журамд заагдаагүй бусад

7 төсөл арга хэмжээнд 59.0 сая төгрөг

Үүнийг графикаар харуулбал: *Дүрслэл № 3 Төсөл арга хэмжээний эзлэх хувь*



Зарим суманд малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний баталсан төсвийг зориулалт бусаар зарцуулахаар 14.0 сая төгрөгийн 3 арга хэмжээ, хуульд заасан чиг үүрэгт хамааралгүй 262.4 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ, төлөвлөснөөс нийт 59.0 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.6.1¹⁰ дэх заалтыг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

10 4.6 ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй:
4.6.1.Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгийг энэхүү журмын 4.5-д заасан зорилгоор;



Хүснэгт№6 Хууль, журамд заасан чиг үүрэгт хамааралгүй төсөл, арга хэмжээний дүн

мянган төгрөг

Д/д	Сумдын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Олгосон санхүүжилт
1	Ихтамир	Малчдын бүтээгдэхүүн хадгалах хөргүүр барих	20,000.0	20,000.0
2	Хангай	Мал нядалгааны цех барих	47,000.0	-
		Цехийн зураг төсвийн үнэ	3,000.0	3,000.0
3	Хотонт	Малчдын хөрзөн гаргахад зориулсан трактор худалдан авах	87,400.0	-
4	Эрдэнэмандал	Мал нядалгааны цех /оролцоо/	78,000.0	-
		Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн нэгжийн үйл ажиллагааны урсгал зардалд	13,600.0	13,600.0
		Малын үүлдэр угсааг сайжруулах арга хэмжээний төсвөөс малын үзэсгэлэн худалдааны зардалд	5,000.0	5,000.0
		Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс сумын цагдаагийн машины засвар, сэлбэг худалдан авах	3,500.0	3,500.0
		Малчдын байгаль орчныг бохирдуулсны төлбөрийн хөнгөлөлтөд	8,400.0	8,400.0
5	Цэнхэр	Мал эмнэлгийн тасгийн тоног төхөөрөмж худалдан авах	5,000.0	-
6	Хайрхан	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нэрийдлээр асар майхан худалдан авахад	5,500.0	5,500.0
Дүн			276,400.0	59,000.0

Аудитаас зөрчлийг таслан зогсоох, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлагыг дээрх сумдын Засаг даргад хүргүүлээд байна.

Хайрхан сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 22-ны "Тодотгосон төсөв батлах тухай" тогтоолоор 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй малын үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр "Хээлтүүлэгч бэлтгэх" төсөл арга хэмжээг ИТХ-аар батлаагүй байхад 2022 оны 12 дугаар сарын 22-нд 20.0 сая төгрөгийг шилжүүлсэн, хээлтүүлэгч малыг хүлээн аваагүй, бүртгэл тайланд авлагаар тусгаж тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 "ОНХС-ийн хөрөнгийг ... орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал тусгана" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Аудитаас зөрчлийг таслан зогсоох, хөрөнгийг хүлээн авч бүртгэл тайланд тусгах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлээд байна.




Б.2 Нийт төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 29.0 хувь буюу 1,202.9 сая төгрөгийн ажил нь татварын орлого бүрдүүлэлтээс хамаарч хэрэгжээгүй байна.

Б2.1 Нийт төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 29.0 хувь нь хэрэгжээгүй байна.

Дүрслэл №4 Төсөл арга хэмжээний гүйцэтгэл

Малын тоо толгойн албан татварын орлогоос 2022 онд 3,626.3 сая төгрөгийн 178 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1,764.6 сая төгрөгийн 117 төсөл арга хэмжээ бүрэн, 365.6 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжүүлсэн бол 1,202.9 сая төгрөгийн 52 төсөл арга хэмжээг огт хэрэгжүүлээгүй байна.



Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө” гэж заасны дагуу малын тоо толгойн албан татвар нь оны эцэст төвлөрөхөөр байгаа нь төлөвлөсөн арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр дутагдахад нөлөөлж байгаа бөгөөд цаг хугацааны хувьд төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байдал үүсэж байгаа байдал ажиглагдлаа.

Ижил төстэй төсөл арга хэмжээг харилцан адилгүй үнэ өртгөөр төлөвлөж, хэрэгжүүлсэн байдал ажиглагдлаа. Тухайлбал худаг гаргах төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн өртгийн судалгааг харьцуулан авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- ✚ Өлзийт сум 1 худгийг 24.0 сая төгрөгөөр;
- ✚ Хашаат сум 5 худаг 80.0 сая төгрөгөөр /1 худгийг 16.0 сая төгрөг/
- ✚ Эрдэнэбулган сум 2 худгийг 71.5 сая төгрөгөөр /1 худгийг 35.7 сая төгрөг/
- ✚ Өгийнуур сум 5 багийн худаг засварлахад 70.7 сая /1 худгийг дунджаар 14.1 сая төгрөг/
- ✚ Цэнхэр сум 4 худгийн цооног гаргахад 53.9 сая төгрөг /1 худгийн цооног 13.5 сая төгрөг/
- ✚ Эрдэнэмандал сум 5 худгийн цооног гаргахад 85.5 сая төгрөг /1 худаг 17.1 сая төгрөг/
- ✚ Хайрхан сум 1 иж бүрэн худгийг 19.5 сая, 8 худгийн цооног гаргахад 100 сая төгрөг /1 худаг 12.5 сая төгрөг/

Б2.2 Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь малчдад чиглэж үр дүнгээ үзүүлж байна.

Тайлант онд малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 32.7 хувь нь бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг



нэмэгдүүлэх, сайжруулахад, 14.8 хувь нь малын эрүүл мэндийг хамгаалах буюу мал тарилгын хашаа барих, вакцинжуулалтад зарцуулсан нь мал болон малчдад чиглэсэн арга хэмжээ болсон байна.

Б.3 Малын тоо толгойн албан татварын санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

Б.3.1 Малын тоо толгойн албан татварын санхүүжилтээр бий болсон хөрөнгийг түүвэрлэн үзэхэд хөрөнгийн ашиглалт хэвийн байна.

Аудитаар Малын тоо толгойн албан татварын санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдлыг түүвэрлэн Эрдэнэмандал, Ихтамир, Эрдэнэбулган суманд газар дээр нь очиж шалгалаа.

Эрдэнэмандал сумын тухайд:

2022 онд 441.5 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 252.8 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээ бүрэн, 96.5 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ дутуу, 78.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Өвс тэжээлийн фондын барилга барих, малын бэлчээрт уст цэг, худаг гаргах, байгаль орчныг хамгаалах, мод тарих, цөм сүргийг өргөжүүлэх зэрэг төсөл арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлуудын ашиглалт хадгалалт хамгаалалт хэвийн байна.



Зураг -1 Өвсний фондын барилга



Зураг -2 Бэлчээрт худаг, уст цэг гаргах



Зураг -3 байгаль орчныг хамгаалах, мод үржүүлэг



Зураг -4 Цөм сүрэг байгуулах

Ихтамир сумын тухайд:

2022 онд 319.5 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 190.4 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ бүрэн, 45.5 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ дутуу, 78.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Малын эрүүл мэндийг хамгаалах хүрээнд мал, малын бэлчээр, хашаа хороог ариутгах халдваргүйжүүлэх машин худалдан авах, өвс тэжээл марааны фонд бий болгох, малчдын бүтээгдэхүүн хадгалах хөргүүр барих зэрэг төсөл арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлуудын ашиглалт хадгалалт хамгаалалт хэвийн байна.



Зураг -5 Малчдын бүтээгдэхүүн хадгалах хөргүүрийн барилга



Зураг -6 Малын эрүүл мэндийг хамгаалах хүрээнд мал, малын бэлчээр, хашаа хороог ариутгах халдваргүйжүүлэх машин

Эрдэнэбулган сумын тухайд:

2022 онд 169.8 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 40.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ бүрэн, 71.5 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ дутуу, 49.2 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Бэлчээрийн худаг гаргах, булгийн эхийг хашиж засварлах төсөл арга хэмжээний хүрээнд Эрдэнэбулган сумын малчид нутагладаг газруудад хийгдсэн ажлуудын ашиглалт хадгалалт хамгаалалт хэвийн байна.



Зураг -7 булгийн эхийг хаших ажил



Зураг -8 Бэлчээрийн худаг гаргах / дутуу хийгдсэн /



Б3.2 Малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг түүвэрлэн үзэхэд хадгалалт, хамгаалалт зохистой байна

Аудитаар Малын тоо толгойн албан татварын санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдлыг түүвэрлэн Эрдэнэмандал, Ихтамир, Эрдэнэбулган суманд газар дээр нь очиж шалгахад хөрөнгийн хадгалалт хамгаалалт зохистой байна.

БҮЛЭГ 3. МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

В.1. Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах үйл ажиллагаанд тавих хяналт үр дүн багатай байна.

В.1.1. Малын тоо толгойн албан татвар ногдуулалт, бүрдүүлэлтэд Татварын хэлтсээс үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавьж, сумдын татварын байцаагчийн ажлыг дүгнэлт гол үзүүлэлт болгон ажиллаж байгаа ч Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 25.2 хувиар тасарсан, 2023 оны эхний хагас жилийн байдлаар 834.3 сая төгрөгийн малчин болон мал бүхий иргэнээс авах тооцоотой байгаа нь аймгийн Татварын хэлтсийн зүгээс тавих хяналт үр дүн бага байгааг харуулж байна.

В.1.2. Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байгаа ч хэрэгжилт хангалтгүй байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т “Энэ хуулийн дагуу албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам, тайлангийн маягыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална” гэж заасны дагуу Татварын ерөнхий газрын даргын 2021 оны 21 дүгээр сарын 18-ны өдрийн А/09 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар” Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам”-ыг баталж, аймгийн Татварын хэлтэс нь хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байгаа боловч тус журмын зарим зүйл заалт бодит байдал дээр хэрэгжихэд хүндрэлтэй, мөн “Татварын нэгдсэн систем”-ийн хөгжүүлэлт, хоорондын уялдаа холбоо сул зэргээс шалтгаалж, хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитаас “Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д үүсгэсэн албан татварын ногдуулалт, тайлан мэдээний үнэн зөв байдалд тавьж, программын хөгжүүлэлт сайжруулалтад анхаарч, хууль журмын хэрэгжилтийг хангуулан ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

В2. Малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.



В.2.1. Малын тоо толгойн албан татвараас санхүүжсэн ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тавих хяналт болон захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлээгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4¹¹-д заасны дагуу малын тоо толгойн албан татвар болон ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт хийсэн талаарх тайлан мэдээг сумдаар нэгтгэн ирүүлэх талаар аймгийн ИТХ-д 2023 оны 06 дугаар сарын 20-ны 233 дугаартай албан бичгийг хүргүүлж, 2023 оны 06 дугаар сарын 23-ны 77 дугаар албан бичгээр хариуг хүлээн авахад малын тоо толгойн албан татвар болон ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлээгүй, 2023 оны 3 дугаар улиралд хийгдэхээр төлөвлөгдсөн, сумдаас хяналт хийсэн тайлан мэдээ ирүүлээгүй гэсэн байна.

В.2.2. Малын тоо толгойн албан татвараас санхүүжүүлсэн ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Малын тоо толгойн албан татвараас санхүүжсэн ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлж, гэрээг дүгнэж ажилласан эсэхийг хянахад төсөл арга хэмжээг дутуу хэрэгжүүлж, гэрээг дүгнэж ажиллаагүй дараах зөрчил илэрч аудитаас зөрчлийг арилгуулах албан шаардлагыг сумдын засаг дарга нарт хүргүүлээд байна. Үүнд:

- Эрдэнэмандал сум малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр "Өвс тэжээлийн фонд барих" ажлыг 96.5 сая төгрөгөөр гэрээ байгуулан 67.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд гэрээт ажлыг гүйцэтгэгч байгууллага хугацаанд нь дуусгаж хүлээлгэн өгөөгүй, захиалагчийн зүгээс хяналт тавьж холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.
- Чулуут сум малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр тус бүр нь 22.7 сая төгрөгийн өртөгтэй "Худаг гаргах" 3-н ажлыг нийт 68.1 сая төгрөгөөр байгуулан 40.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд гэрээт ажлыг гүйцэтгэгч байгууллага хугацаанд нь дуусгаагүй, захиалагчийн зүгээс хяналт тавьж холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.
- Эрдэнэбулган сум малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр "Бэлчээрийн худаг гаргах" ажлыг 70.3 сая төгрөгөөр гэрээ байгуулан 42.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд гэрээт ажлыг гүйцэтгэгч байгууллага хугацаанд нь дуусгаагүй, захиалагчийн зүгээс хяналт тавьж холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Дээрх зөрчил нь Засгийн Газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.2.2-т "Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд

¹¹ "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9.4-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина"



хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах ...", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.3 -т "Сум, дүүргийн засаг дарга нь сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, **хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй**" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

В2.3. Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад дотоод аудит, бусад хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилт, ОНХС-ийн 2022 оны зарцуулалтад аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9.4-9.5-д заасан хяналт хийгээгүй байна. /Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2023.06.09-ны өдрийн 84 тоот албан бичиг/

Аудитаас тус журмын хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

В3. Малын тоо толгойн албан татвараас санхүүжүүлсэн ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцын мэдээллийг зарим сумд удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулаагүй байна.

В3.1. Малын тоо толгойн албан татвараар санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг журам, зааврын дагуу тайлагнаж байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9.11-д заасны дагуу ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг мэдээг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна.

В3.2. Малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн 16.9 хувийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Тайлант онд Малын тоо толгойн албан татвараас санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний 60.6 хувь буюу 1,194.0 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн бол 39.4 хувь буюу 777.8 сая төгрөгөөр урсгал зардлыг санхүүжүүлсэн байна.

Нийт бэлтгэсэн үндсэн хөрөнгийн 16.9 хувь буюу 201.2 сая төгрөгийн 5 төрлийн хөрөнгийг тухайн байгууллагын хөрөнгийн бүртгэл тайланд тусгаагүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 7 Бүртгэл тайланд тусгаагүй хөрөнгө

/ мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	Хөрөнгийн нэр	Дүн
1	Ихтамир	Малын тэжээл	52,000.0
2	Өндөр-Улаан	Худаг	45,000.0
3	Эрдэнэмандал	Өвс тэжээлийн фондын барилга	67,545.0
4	Хайрхан	Хээлтүүлэгч мал	20,000.0
5	Цэнхэр сум	Мал угаалгын ванн	16,676.2
Дүн			201,221.2



Аудитаас зөрчлийг арилгах, үндсэн хөрөнгийг шалгаж хүлээн аван, нягтлан бодох бүртгэл тайланд тусгах албан шаардлагыг Ихтамир, Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Хайрхан, Цэнхэр сумын Засаг дарга нарт хүргүүлээд байна.

В3.3. Малын тоо толгойн албан татвараас санхүүжүүлсэн ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд оруулж, иргэдэд ил тод нээлттэй мэдээлж байгаа ч зарим сумын ЗДТГ-аас мэдээллийг үнэн зөв, бүрэн байршуулаагүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.2.3-т "... ЗДТГ-ын албан тушаалтанд өгч, тус албан тушаалтан Удирдлага мэдээллийн системд оруулна", 3.4.5-д "ОНХС-ийн Удирдлага мэдээллийн системийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт цэсэд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулах" гэж заасан. Хэрэгжилтийг хянан үзэхэд Хайрхан, Эрдэнэбулган сумын ЗДТГ-аас малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг системд үнэн зөв, бүрэн мэдээлээгүй, Тариат, Өндөр-Улаан, Цэнхэр, Чулуут сумын ЗДТГ-аас мэдээллийг дутуу байршуулсан зөрчил илэрлээ. Иймд аудитаас зөрчлийг арилгаж мэдээллийг бүрэн, нөхөн байршуулах албан шаардлага, зөвлөмжийг хүргүүллээ.

---oOo---



АУДИТЫН ДҮН, ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүн, тайланд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Малын тоо толгойн албан татварыг хуульд заасны дагуу бүрэн ногдуулаагүй, орлого бүрдүүлэлт хангалтгүй байна.
- Сумын ИТХ, ЗДТГ нь сумын ОНХС-д төвлөрөх малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлсэн 406.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 20 төсөл арга хэмжээг иргэдийн саналгүйгээр төлөвлөж гүйцэтгэсэн байна.
- Хуульд заасан чиг үүрэгт хамааралгүй 59.0 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.
- Нийт төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 29.0 хувь буюу 1,202.9 сая төгрөгийн ажил нь татварын орлого бүрдүүлэлтээс хамаарч хэрэгжээгүй байна.
- Малын тоо толгойн албан татварын санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байгаа ч зарим хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.
- Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах үйл ажиллагаанд тавих хяналт үр дүн багатай байна.
- Малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжүүлсэн ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцын мэдээллийг зарим сумд удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулаагүй байна.

Аудитаар нийт 1,686.4 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулах 20 албан шаардлага, 7 зөвлөмжийг аймгийн ИТХ, аймаг, сумдын засаг дарга, аймгийн Татварын хэлтэст хүргүүллээ.



ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүн, тайланд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн ИТХ-ын дарга Б.Батжаргалд

1. Малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлэх ТАХ-г батлахад Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8, “ОНХС-ийн журмын 4.4 дэх заалтыг мөрдөн, хөрөнгийн зарцуулалт, үр дүнд аймаг, сумын ИТХ-аас тавих хяналтыг хэрэгжүүлэх

Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмидад

1. Сангийн Сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4¹², 9.5¹³, 10.3.4¹⁴-т заасны дагуу Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба болон ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах.

Аймгийн Татварын хэлтсийн дарга Б.Эрдэнэбилэгт:

1. Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн Малын тоо толгойн албан татварын ногдуулалтын тайлан, мэдээ, судалгаа хоорондоо зөрүүтэй, уялдаагүй байгаад дүгнэлт хийж "Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-д үүсгэсэн албан татварын ногдуулалт, тайлан мэдээний үнэн зөв байдалд тавих хяналтыг сайжруулах

Сумын ИТХ-ын дарга нарт:

1. ОНХС-ийн журмын 3.2.2-т заасны чиг үүргийн дагуу хэрэгжсэн төсөл арга хэмжээнд хяналт тавьж, үр дүнг ИТХ-аар хэлэлцэх, иргэдийн саналд үндэслээгүй, чиг үүрэгт хамаарахгүй төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар батлахгүй байх

Сумын засаг дарга нарт:

1. Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний гүйцэтгэлд хяналтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах
2. Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээний талаар иргэд, олон нийт малчдад мэдээллийг бүрэн хүргэж ажиллах

Зөвлөмжийн хариуг **2023 оны 12 сарын 10-ны өдрийн дотор** Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

¹² “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина”

¹³ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ

¹⁴ Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь аймаг, нийслэлийн, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь сум, дүүргийн ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилттэй холбоотой хийгдсэн аудит, хяналт шалгалтын тайлан, дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлага болон бусад мэдээллийг мэдээллийн хэрэгслээр дамжуулан хагас, бүтэн жилээр мэдээлнэ



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



АРХАНГАЙ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС

2 дугаар баг, Эрдэнэбулган сум,
Архангай аймаг, 65139
Утас: 7033 3235, Факс: (976) 7033 3235
Цахим шуудан: arkhangai@mta.gov.mn

2023.07.07 № 01/333
танай 2023.07.07-ны № 256 -г

АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

Нийцлийн аудитын тайлангийн А.1.1-д ногдуулалтыг бүрэн хийгээгүй, Татварын нэгдсэн системд сумдын татварын улсын байцаагч нар татварын нэхэмжлэхийг дутуу үүсгэсэн гэсэн байна.

Малын тоо толгойн албан татварын ногдуулалтыг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно гэсний дагуу Статистикийн хэлтсийн ирүүлсэн мэдээлэлд үндэслэн хийдэг. "Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам"-ын 2.2-т заасны дагуу Үндэсний статистикийн хороо нь мал тооллогын нэгдсэн дүн мэдээг 02 дугаар сарын 15-ны дотор Татварын ерөнхий газарт ирүүлдэг бөгөөд энэ мэдээллийг үндэслэн Татварын ерөнхий газар татварын удирдлагын нэгдсэн системд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоосоон хувь хэмжээгээр мэдээллийн сан үүсгэдэг. Сумдын байцаагч татварын удирдлагын нэгдсэн системийн мэдээлэл болон сумын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнээс тоо мэдээг авч татварын удирдлагын нэгдсэн системд малчин бүрээр татварын нэхэмжлэлийг үүсгэн тайлант оны малын тоо толгойн албан татварыг төлүүлж төсөвт төвлөрүүлдэг. Хэрэв урьд оны татвараа төлөөгүй өртэй бол тайлант оны нэхэмжлэл үүсэхгүй тул статистикийн тоо мэдээнд үндэслэн тооцоолсон ногдуулалт татварын удирдлагын нэгдсэн системд үүссэн ногдуулалт хоёр зөрүүтэй буюу аудитын тайланд тусгасан 292.3 сая төгрөгөөр дутуу харагдаж байна. Урд оны дутуу өрийг төлүүлсэний дараа дараагийн жилийн нэхэмжлэлийг үүсгэж төлүүлдэг болно.

ДАРГА



Б.ЭРДЭНЭБИЛЭГ

6523030178



**АРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139
Утас/Факс: (976) 7033 3231,
Цахим шуудан: arkhangai.gov@gmail.com,
Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

2023.07.07 № 08/1219
танай 2023.07.07-ны № 258 -г

**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Малын тоо толгойн албан татварын хувь
хэмжээг тогтоох, орлого төлөвлөх, зарцуулах
асуудлыг сумын ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж
ажиллахаар хуульчлагдсан байдаг.

Манай хэлтсээс зөвлөмж, чиглэл хүргүүлж
ажилладаг ба тайлангийн төсөлд санал байхгүй
болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САЛГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Ж.МӨНХБАТ



6523901250



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/33

Цэцэрлэг

Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрх, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9, 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар "Эрх үүрэг шилжүүлэх" тушаалын тавдугаар хавсралтын 1.3, 2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн "Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилт, сумын 2022 оны татварын орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай

2. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Аймгийн ИТХ, Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэст хүргүүлсүгэй.

4.Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Нэргүйбаатар), ахлах аудитор (Н.Алтантуяа) нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 1/33 тоот тушаалын хавсралт

"Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилт, сумын 2022 оны татварын орлогын бүрдүүлэлт, зарцуулалт" аудитаар хүргүүлсэн шийдвэрийн жагсаалт

№	Хүргүүлсэн шийдвэрийн				Огноо дугаар	Хэрэгжилтийг хариуцах	
	Утга	Мөнгөн дүн /сая.төг/	Тоо	Шийдвэр		Байгууллага нэр, албан тушаал	Овог нэр
1	Зөрчил арилгуулах тухай	96.5	1	Албан шаардлага	2023.07.07 385/A0360212	Эрдэнэмандал сумын засаг дарга	Д.Лхагвадорж
2	Зөрчил арилгуулах тухай	20.0	1	Албан шаардлага	2023.07.07 386/A0360212	Хайрхан сумын засаг дарга	Л.Чойжжанцан
3	Зөрчил арилгуулах тухай	78.2	1	Албан шаардлага	2023.07.07 387/A0360212	Хайрхан сумын засаг дарга	Л.Чойжжанцан
4	Зөрчил арилгуулах тухай	5.5	1	Албан шаардлага	2023.07.07 388/A0360212	Хайрхан сумын засаг дарга	Л.Чойжжанцан
5	Зөрчил арилгуулах тухай	-	1	Албан шаардлага	2023.07.07 389/A0360212	Хайрхан сумын засаг дарга	Л.Чойжжанцан
6	Зөрчил арилгуулах тухай	45.0	1	Албан шаардлага	2023.07.07 390/A0360212	Өндөр-Улаан сумын засаг дарга	Ю.Баасанжаргал
7	Зөрчил арилгуулах тухай	20.0	1	Албан шаардлага	2023.07.07 391/A0360212	Өндөр-Улаан сумын засаг дарга	Ю.Баасанжаргал
8	Зөрчил арилгуулах тухай	16.7	1	Албан шаардлага	2023.07.07 392/A0360212	Цэнхэр сумын засаг дарга	Д.Галхүү
9	Зөрчил арилгуулах тухай	68.1	1	Албан шаардлага	2023.07.07 393/A0360212	Чулуут сумын засаг дарга	Э.Анхбаяр
10	Зөрчил арилгуулах тухай	23.0	1	Албан шаардлага	2023.07.07 394/A0360212	Чулуут сумын засаг дарга	Э.Анхбаяр
11	Зөрчил арилгуулах тухай	52.0	1	Албан шаардлага	2023.07.07 395/A0370462	Ихтамир сумын засаг дарга	Б.Цэвээндорж
12	Зөрчил арилгуулах тухай	-	1	Албан шаардлага	2023.07.07 396/A0370462	Ихтамир сумын засаг дарга	Б.Цэвээндорж
13	Зөрчил арилгуулах тухай	20.0	1	Албан шаардлага	2023.07.07 397/A0370462	Ихтамир сумын засаг дарга	Б.Цэвээндорж
14	Зөрчил арилгуулах тухай	138.4	1	Албан шаардлага	2023.07.07 398/A0370462	Ихтамир сумын засаг дарга	Б.Цэвээндорж
15	Зөрчил арилгуулах тухай	71.5	1	Албан шаардлага	2023.07.07 399/A0370462	Эрдэнэбулган сумын засаг дарга	Д.Мөнхбат
16	Зөрчил арилгуулах тухай	82.2	1	Албан шаардлага	2023.07.07 400/A0370462	Эрдэнэбулган сумын засаг дарга	Д.Мөнхбат



17	Зөрчил арилгуулах тухай	-	1	Албан шаардлага	2023.07.07 401/A0370462	Эрдэнэбулган сумын засаг дарга	Д.Мөнхбат
18	Зөрчил арилгуулах тухай	50.0	1	Албан шаардлага	2023.07.07 402/A0370462	Хангай сумын засаг дарга	Д.Өрнөхбаяр
19	Зөрчил арилгуулах тухай	65.0	1	Албан шаардлага	2023.07.07 403/A0370462	Тариат сумын засаг дарга	Б.Буяннэмэх
20	Зөрчил арилгуулах тухай	834.3	1	Албан шаардлага	2023.07.07 404/A0360212	Аймгийн Татварын хэлтсийн дарга	Д.Эрдэнэбилэг
21	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	-	1	Зөвлөмж хүргүүлэх	2023.07.07 /тайлангаар/	Аймгийн Татварын хэлтсийн дарга	Д.Эрдэнэбилэг
22	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	-	1	Зөвлөмж хүргүүлэх	2023.07.07 /тайлангаар/	Аймгийн ИТХ-ын дарга	Б.Батжаргал
23	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	-	1	Зөвлөмж хүргүүлэх	2023.07.07 /тайлангаар/	Аймгийн Засаг дарга	Б.Цэрэннадмид
24	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	-	1	Зөвлөмж хүргүүлэх	2023.07.07 №103	Өндөр-Улаан сумын засаг дарга	Ю.Баасанжаргал
25	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	-	1	Зөвлөмж хүргүүлэх	2023.07.07 №104	Цэнхэр сумын засаг дарга	Д.Галхүү
26	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	-	1	Зөвлөмж хүргүүлэх	2023.07.07 №105	Чулуут сумын засаг дарга	Э.Анхбаяр
27	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	-	1	Зөвлөмж хүргүүлэх	2023.07.07 №106	Тариат сумын засаг дарга	Б.Буяннэмэх
Албан шаардлагын дүн		1,686.4	20				
Зөвлөмжийн		0.0	7				
НИЙТ ДҮН		1,686.4	27				